



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/57

Хархорин сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын эрүүл мэндийг хамгаалах (Дук машин) нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Үнэлгээний хорооны дарга: Н.Нямдаваа (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: З.Энхтүвшин (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг: С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, дүгнэлт гарган танилцуулахыг Үнэлгээний хороо (Н.Нямдаваа)-д даалгасугай.

3.Төндөр шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (С.Мөнхсоёл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

